

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Уг хуулийн төслөөр даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилтыг тодорхойлсон байна.

Иймд хуулийг хэрэгжүүлэх байгууллага, даатгагч, даатгуулагчид нөлөөлөл үзүүлэх зардлыг тооцов.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- ✓ Хуулийн этгээд, төрийн байгууллага, даатгуулагчийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох.
- ✓ Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- ✓ Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- ✓ Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо аргачлалын 2.1-д заасны дагуу

- 1) Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) Зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах;

6) Нэмэлт зардлыг тооцох үе шатаар хуульд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарах мөнгөн зардлыг тооцсон.

1.1.Заавал даатгалын холбооны үйл ажиллагаатай холбоотой зардлын тооцоо:

➤ Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд заасны дагуу Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Албан журмын даатгагчдын холбоонд гишүүн болох үүрэгтэй бөгөөд тус холбоо нь албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн сан, даатгалын тохиолдлыг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий шуурхай алба, мөн албан журмын даатгалын сантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасны дагуу Заавал даатгалын холбоо нь одоогийн үйл ажиллагаа явуулж буй Албан журмын даатгагчдын холбооны мэдээллийн нэгдсэн сан, даатгалын сангийн үйл ажиллагаанаас гадна даатгалын зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх, тайлан гаргах, заавал даатгалын эрсдэл хураамж болон үнэлгээний доод хэмжээг тогтоох талаар судалгаа хийх, итгэлцүүр тогтоох санал хүргүүлэх зэрэг чиг үүргийг нэмж хэрэгжүүлнэ.

Иймд одоогийн үйл ажиллагаа явуулж буй Албан журмын даатгагчдын холбоог өргөжүүлэн, өөрчлөн байгуулах замаар Заавал даатгалын холбоог байгуулахаар байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Өргөдөл гаргагч нь өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлэхээр байна. Үүнд:

- 1.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт;
- 2.баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- 3.үүсгэн байгуулах баримт бичиг буюу хуулийн этгээд байгуулах шийдвэр /тогтоол/, дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээ;
- 4.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;
- 5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- 6.эрх залгамжлалын талаарх өөрчлөлтийг оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг;
- 7.өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан тэнцэл
- 8.улсын бүртгэлийн гэрчилгээ
- 9.өөрчлөн байгуулах тохиолдолд Иргэний хуулийн 38.3-т заасны дагуу эд хөрөнгийг шилжүүлсэн тухай холбогдох байгууллагын шийдвэр

Иймд шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах захиргааны зардал гарахаар байна. Үүнд:

Хүснэгт-1

Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа /мин/	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Хуулийн этгээдийн шинэчилсэн	Нэрийн баталгаажуулалт хийлгэх	40	1	40
	Өргөдөл гаргах	30	1	50

бүртгэлд бүртгүүлэх	Холбогдох материалыг бүрдүүлэх	480	1	480
	Улсын тэмдэгтийн хураамж төлөх	30	1	30
	Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлэх	60	1	60
Нийт		660 мин буюу 11 цаг		

Холбоонд ажиллах мэргэжилтний дундаж цалин хөлсийг **1,750.2 мянган төгрөг** гэж тооцлоо.¹ Харин ажилтны сард ажиллах хугацаа нь **22 хоног буюу 176 цаг /10560 минут/** байна.

Хүснэгт-2

Үндсэн цалин /төг/	1 минутад ногдох ажлын хөлс /төг/	Дээрх ажлыг гүйцэтгэхэд	
		Зарцуулах хугацаа /мин/	Нийт ажлын хөлс /төг/
1,750,200	165.7	660	109,387.5

Иймд энэхүү үүргийг нэг удаа гүйцэтгэхэд цалингийн зардал **109,387.5 төгрөг** зарцуулахаар байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу холбоог бүртгүүлэхэд “Байгууллагын дүрэм” болон шаардлагатай бусад баримт бичгийг хуульд нийцүүлэн боловсруулах, Удирдах зөвлөлийн гишүүдийг хуралдуулах зэрэг бэлтгэл ажиллагааг хангах шаардлагатай болно. Гэвч эдгээр ажилд зарцуулах цаг хугацаа, зардал өөр өөр байх тул холбогдон гарах зардлыг тооцоонд тусгаагүй болно.

Харин Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн мэдээлэлд үндэслэн хуулийн этгээдийг бүртгүүлэхэд дараах зардал гарахаар байна.

Хүснэгт-3

д/д	Зардлын төрөл	Зардал /төг/
1	Нэр баталгаажуулалтын үйлчилгээний хөлс	10,000.0
2	Улсын тэмдэгтийн хураамж	44,000.0
3	Тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох үйлчилгээний хөлс	10,000.0
	НИЙТ	64,000.0

Иймд Холбоог улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотойгоор **ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ+БУСАД ЗАРДАЛ** шаардлагатай байна.

Хүснэгт-4

д/д	Зардлын төрөл	Зардал /төг/
1	Захиргааны зардал /цалин/	109,387.5
2	Бусад зардал	64,000.0
	НИЙТ	173,387.5

- **Заавал даатгалын холбооны үйл ажиллагаатай холбоотой зардлын тооцоо:**

¹ www.1212.mn, 2022 оны 4 улирлын дундаж цалин

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 65 дугаар зүйлд Заавал даатгалын холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- заавал даатгалын баталгаат сангийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах;
- даатгалын мэдээллийн санг бүрдүүлэх, удирдах, хөгжүүлэх, өргөжүүлэх, түүний аюулгүй байдлыг хангах;
- даатгалын зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх, тайлан гаргах;
- заавал даатгалын эрсдэл, хураамж болон үнэлгээний доод хэмжээг тогтоох талаар судалгаа хийх, итгэлцүүр тогтоох саналаа Хороонд хүргүүлэх;
- даатгалын тохиолдлыг бууруулах чиглэлээр заавал даатгалын сургалт, сурталчилгаа явуулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах

Тус холбоо нь хуулийн төсөлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний нөөцийн болон захиргааны зардал гарахаар байна.

Тус холбооны ажлын албаны орон тоог одоо үйл ажиллагаа явуулж байгаа Албан журмын даатгагчдын холбооны ажлын албаны бүтэц, орон тоотой адилтган Гүйцэтгэх захирал-1, Захиргааны алба - 5 мэргэжилтэн, Заавал даатгалын сангийн алба - 3 мэргэжилтэн, Мэдээллийн сангийн алба - 5 мэргэжилтэн, Судалгаа шинжилгээний алба – 3 мэргэжилтэн, нийт 17 орон тоотой ажиллахаар тооцон гаргалаа.

Засгийн газрын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-ийг ашиглан тус холбооны албан хаагчтай холбогдон гарах “материаллаг зардал”-ыг тооцооллоо.

Материаллаг зардал: Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Дэс түшмэл /түүнтэй адилтгах албан тушаалтан/

Хүснэгт-5

№	Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ
1	Хувцасны өлгүүр /шүүгээ/	1
2	Шалны дэвсгэр	1
3	Бичгийн ширээ	1
4	Бичгийн ширээний сандал	1
5	Компьютер иж бүрдэл	1
6	Телефон утас	1
7	Тооны машин	1
8	Сэтгүүлийн ширээ	1
9	Компьютерийн ширээ	1

“Нэг албан тушаалтанд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна. Хэд хэдэн ажилтан нэг өрөөнд суудаг бол дундаа ашиглах телефон утас, нэгдсэн холболт бүхий принтер, хувцасны өлгүүртэй байна” гэж заасныг материаллаг зардлын тооцоог гаргахад ашиглав.

Иймд тус Холбооны ажлын албанд бичгийн ширээ-17, бичгийн ширээний сандал-17, компьютер иж бүрдэл-17, бичиг хэрэг хадгалах шүүгээ-17, бусад хөрөнгө 5 ажилтан тутамд 1 гэж тооцож, тус бүр-4 шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.

Мөн албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал гарах бөгөөд Холбоо нь түрээс, бусад ашиглалтын зардалд дунджаар сард 5,000.0 төгрөг, жилд 60,000.0 төгрөгийн зардал гарахаар тооцооллоо.

Хүний нөөцийн зардал:

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Нэг албан хаагчид зарцуулах, зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ буцалтгүй тусламж, 4/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 20%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцооллоо.

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын дүнгээр сарын голч цалин 1,750.2 мянган төгрөг байна.

Хүснэгт-6

Зардлын нэр	Цалингийн хэмжээ	Хувь	Хэмжээ
Үндсэн зардал	1,750,200		1,750,200
Нийтлэг зардал	1,750,200	15%	262,530
Дагалдах зардал	1,750,200	10%	175,020
Нэмэгдэл урамшууллын зардал	1,750,200	20%	350,040
Нийт			2,537,790

Хүснэгт-7

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн 1 жилд зарцуулах зардал /төг/
Ажилтан	2,537,790	17	12	517,709,160
Нийт хүний нөөцийн зардал				517,709,160

Бусад зардал:

Хуулийн төсөлд тусгасны дагуу Заавал даатгалын холбоо нь “заавал даатгалын сангийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах; мөн даатгалын мэдээллийн санг удирдах, түүний аюулгүй байдлыг хангах” чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор заавал даатгалын сан болон мэдээллийн санг байгуулах шаардлагатай бөгөөд тус сангуудыг байгуулахад тодорхой хэмжээний зардал гарч болзошгүй юм.

Гэхдээ, одоогийн мөрдөгдөж байгаа Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1 “Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна: 23.1.1. энэ хуулийн 18.1-д заасан нөхөн төлбөр олгох, 23.1.2. энэ хуулийн 24.1-д заасан жолоочийн даатгалын мэдээллийн сан хөтлөх...” гэж заасан. Мөн хуулийн 18.1 “Дараах үндэслэлийн аль нэг нь байвал жолоочийн даатгалын сан хохирогчийн өргөдлийг үндэслэн түүнд нөхөн төлбөр олгоно: 18.1.4.даатгагч дампуурсан” гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл, даатгагч дампуурсны улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс сэргийлэх зориулалттай сан болон мэдээллийн сан одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа Албан журмын даатгагчдын холбоон дээр байгуулагдсан байгаа болно.

Даатгалын багц хуулийн төсөлд хамаарах Даатгалын тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар Албан журмын даатгагчдын холбоог өргөжүүлэн, Заавал даатгалын холбоо болгон өөрчлөн байгуулах тул одоогийн байгуулагдсан байгаа мэдээллийн сан болон жолоочийн даатгалын сангийн даатгагч дампуурах үед нөхөн төлбөр олгох зориулалттай сан нь Заавал даатгалын холбооны чиг үүрэгт хамаарах мэдээллийн сан болон заавал даатгалын сангийн суурийг бүрдүүлэх юм.

1.2. Даатгалын компаниудад үүсч болзошгүй зардлын тооцоо:

➤ Хуулийн төслийн 65.1-т “Хорооноос заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Заавал даатгалын холбоонд гишүүн болох үүрэгтэй” гэж заасан. 2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.²

Иймд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй Албан журмын даатгагчдын холбооны гишүүн даатгагч нар Заавал даатгалын холбоонд гишүүнээр элсэж, гишүүнчлэлийн хураамжтай холбоотой тодорхой хэмжээний зардал гаргах боловч одоо Албан журмын даатгагчдын холбоонд төлж буй гишүүнчлэлийн хураамжийг шилжүүлэн үргэлжлүүлэн төлөх тул даатгагч нарт гишүүнчлэлтэй холбоотой нэмэлт зардал гарахгүй гэж тооцлоо.

➤ Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд Жолоочийн даатгалын санг бүрдүүлэх эх үүсвэрийг заасан бөгөөд хуулийн 22.1.-д Жолоочийн даатгалын сан нь жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгөөс бүрдэнэ, мөн хуулийн 22.2-т даатгагч нараас төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр тогтоохоор заасан. Өөрөөр хэлбэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч нар нь жил бүр албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн орлогын дүнгийн тодорхой хувиар Жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлдэг. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 312/206 тоот хамтарсан тушаалаар Жолоочийн даатгалын санд 2021 онд

² Даатгалын салбарын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан. Санхүүгийн зохицуулах хороо.

төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг даатгагч тус бүрийн 2020 оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн орлогын дүнгийн 1.5 хувиар тогтоож, Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэхийг үүрэг болгосон байна.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 66.1-д “Даатгагч дампуурсан, түүний улмаас заавал даатгалын даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нар хамтран заавал даатгалын баталгаат санг байгуулна.” гэсэн шинэ зохицуулалтыг тусгасан. Уг заалтын дагуу заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагч нар нь заавал даатгалын хураамжийн орлогын тодорхой хувийг дээрх санд төвлөрүүлэхээр байгаа бөгөөд Заавал даатгалын баталгаат сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах, түүнийг захиран зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах журмыг Заавал даатгалын холбооны саналыг харгалзан Хороо батлахаар байна.

Иймд даатгагч нарын Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгө тооцох хувийг жишиг болгон заавал даатгалын баталгаат санд төвлөрүүлэх хөрөнгийн хувийг тооцохдоо 1%-иар тооцлоо.

➤ Хүснэгт-9

д/д	Зардлын төрөл	ЖХАЖД-ын орлогод тооцсон хураамж /сая.төг/	Даатгагч нараас төвлөрүүлэх хувь	1 жилд төвлөрүүлэх хөрөнгө /сая.төг/
1	Заавал даатгалын баталгаат сан	34,865.80	1.0%	348.66
	Нийт			348.66

Цаашид заавал даатгагч нараас төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тооцох хувийг тухай бүр тогтоох боломжтой байна.

1.3. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаатай холбоотой зардлын тооцоо:

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 12 дугаар бүлэгт даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Одоогийн мөрдөгдөж буй Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т “даатгалын хохирол үнэлэгч” гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг”, мөн хуулийн 12.1-д “даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн компанид олгоно” гэж заасан. Өөрөөр хэлбэл, даатгалын хохирол үнэлэгч нь Хорооноос даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд байх бөгөөд даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах чиг үүргийг бие даан хэрэгжүүлдэг болно.

Харин Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасны дагуу даатгалын хохирол үнэлэгч нь даатгагчийн томилсон хохирол үнэлэгч болон

хөндлөнгийн хохирол үнэлэгч гэсэн төрөлтэй байх бөгөөд Хороо даатгалын хохирол үнэлэгчээр ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдэд хөндлөнгийн хохирол үнэлэгчийн энгийн зөвшөөрлийг олгохоор тусгасан байна.

Харин даатгагчийн томилсон хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг эрхэлж, даатгалын хохирлын үнэлгээг гаргах бөгөөд даатгуулагч нь даатгагчийн томилсон хохирол үнэлэгчийн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй бол, мөн мэргэжлийн ур чадвар шаардлагатай, нарийн төвөгтэй байдлаар хийгдэх хохирол үнэлгээний хувьд хүсэлт гаргасан тохиолдолд хөндлөнгийн хохирол үнэлэгчид хандана. Түүнчлэн даатгагч нь өөрийн хохирол үнэлэгчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрт Хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэх зохицуулалтыг тусгасан байна.

Иймд дээрх зохицуулалттай холбоотойгоор даатгагчид хохирол үнэлэгч ажилтныг томилох, ажиллуулахтай холбоотой хүний нөөцийн зардал гарах юм.

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Нэг албан хаагчид зарцуулах, зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ буцалтгүй тусламж, 4/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 20%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцооллоо.

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын дүнгээр сарын дундаж цалин 1,750.2 мянган төгрөг байна.

Хүснэгт-10

Зардлын нэр	Цалингийн хэмжээ	Хувь	1 сарын цалин	12 сарын цалин
Үндсэн зардал	1,750,200		1,750,200	21,002,400
Нийтлэг зардал	1,750,200	15%	262,530	3,150,360
Дагалдах зардал	1,750,200	10%	175,020	2,100,240
Нэмэгдэл урамшууллын зардал	1,750,200	20%	350,040	4,200,480
Нийт			2,537,790	30,453,480

Иймд даатгагч нь 1 хохирол үнэлэгчийг томилон, ажиллуулсан тохиолдолд цалингийн зардал 1 сард **2,537.8 мянган төгрөг**, 1 жилд **30,453.5 мянган төгрөг** зарцуулахаар байна.

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараах үе шатаар гүйцэтгэлээ:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах

Одоогийн мөрдөгдөж буй Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байна. Тус хуульд заасны дагуу Хороо нь даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгодог буюу даатгалын хохирол үнэлэгч нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлдэг.

Хуулийн төсөлд тусгасан шинэ зохицуулалттай холбоотойгоор одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын хохирол үнэлэгч нарын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, даатгагчийн томилох хохирол үнэлэгч иргэн болон хөндлөнгийн хохирол үнэлэгч компанид даатгалын хохирол үнэлэгчийн энгийн зөвшөөрлийг тус тус олгоно.

Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, энгийн зөвшөөрөл олгохтой холбоотой ажил үүргийг өнөөгийн Хорооны хүний нөөцийн хэрэгцээгээр хариуцан ажиллах боломжтой бөгөөд улсын төсөвт нэмэлт дарамт үүсгэхгүй гэж тооцсон болно.

ГУРАВ. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Хуулийн төсөл батлагдсанаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжрах, даатгалын салбарт эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоо бүрдэх, дотоодын даатгагч нарын чадавх нэмэгдэх, даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчны тодорхойгүй байдал буурах, даатгалын зах зээлийн бүтэц тэнцвэржих зэрэг эерэг нөлөөг үзүүлнэ. Үүний үр дүнд, даатгалын хамрагдалт, хүртээмж нэмэгдэх, даатгалын зах зээл өргөжих, даатгалын салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэхээс гадна урт хугацаандаа даатгалын салбарыг хөгжүүлэх эрх зүйн суурь бүрэлдэн бий болох ач холбогдолтой болно.

---oOo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
3. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2024 он. Сангийн яам;
4. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2024 он. Сангийн яам;
5. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2024 он. Сангийн яам.
6. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоол;
7. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”;
8. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт;
9. www.1212.mn
10. www.frc.mn Даатгалын салбарын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан.